



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/296

Булган сум

Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 4.32-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Төрийн архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Б.Одхүү (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд: А.Сарантуяа (Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)
Б.Очирсүрэн (Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)
М.Цэрэнчимэд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: А.Оюунжаргал (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)
Э.Болорзул (Төрийн архивын Зааварлагч, арга зүйч)
Д.Баасансүрэн (Төрийн архивын дарга)

2. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар гарсан хууль тогтоомж, заавар журмыг мөрдлөг болгон ажиллахыг комисс (Б.Одхүү)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/258 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010401